

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН 2007 ОНЫ ШҮҮН  
ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮНГИЙН  
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

**Нэг. Эрүүгийн шүүн таслах ажиллагааны талаар**

Анхан шатны шүүхүүд 2007 онд 10398 хүнд холбогдох 6876 эрүүгийн хэрэг хүлээн авч, 788 хүнд холбогдох 411 эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцааж, шүүгдэгч, хохирогч эвлэрснээр болон Өршөөл үзүүлэх тухай хуулиар 216 хүнд холбогдох 182 хэргийг, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэлээр 323 хүнд холбогдох 83 хэргийг цагаатгах тогтоолоор тус тус хэрэгсэхгүй болгож, 8463 хүнд холбогдох 5831 хэргийг таслан шийдвэрлэж, оны эцэст 608 холбогдогчтой 369 хэргийн үлдэгдэлтэй байна.

Өнгөрсөн оноос шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 4.9 хувиар, ял шийтгүүлэгчид 8.6 хувиар өсчээ.

Анхан шатны шүүхээр 2007 онд таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, ял шийтгүүлэгчдийг өмнөх онтой нь харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Эрүүгийн хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн тоо			
		Бүтэн жилд		Өсөлт, бууралт		Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2006 он	2007 он	тоо	хувь	2006 он	2007 он	тоо	хувь
1	Архангай	156	146	-10	-6.4	231	223	-8	-3.5
2	Баян-Өлгий	90	87	-3	-3.3	141	135	-6	-4.3
3	Баянхонгор	114	130	16	14.0	156	177	21	13.5
4	Булган	138	119	-19	-13.8	207	177	-30	-14.5
5	Говь-Алтай	94	77	-17	-18.1	114	98	-16	-14.0
6	Говьсүмбэр	69	63	-6	-8.7	83	81	-2	-2.4
7	Дархан-Уул	356	304	-52	-14.6	554	465	-89	-16.1
8	Дорнод	192	188	-4	-2.1	248	272	24	9.7
9	Дорноговь	210	260	50	23.8	290	332	42	14.5
10	Дундговь	109	110	1	0.9	171	160	-11	-6.4
11	Завхан	120	113	-7	-5.8	161	149	-12	-7.5
12	Орхон	168	243	75	44.6	244	375	131	53.7
13	Өвөрхангай	225	252	27	12.0	316	389	73	23.1
14	Өмнөговь	93	125	32	34.4	143	204	61	42.7
15	Сүхбаатар	91	112	21	23.1	124	139	15	12.1
16	Сэлэнгэ	352	346	-6	-1.7	498	517	19	3.8
17	Төв	161	200	39	24.2	242	295	53	21.9
18	Увс	166	137	-29	-17.5	251	213	-38	-15.1
19	Ховд	201	182	-19	-9.5	243	252	9	3.7
20	Хөвсгөл	162	174	12	7.4	229	236	7	3.1
21	Хэнтий	256	200	-56	-21.9	325	281	-44	-13.5
22	Нийслэл	2035	2263	228	11.2	2821	3293	472	16.7
	<b>Дүн</b>	<b>5558</b>	<b>5831</b>	<b>273</b>	<b>4.9</b>	<b>7792</b>	<b>8463</b>	<b>671</b>	<b>8.6</b>

байдалтай байна.

Таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг Сэлэнгэ, Дорнод, Баян-Өлгий, Завхан, Архангай, Говьсүмбэр, Ховд, Булган, Дархан-Уул, Увс, Говь-Алтай, Хэнтий аймаг, 1.7-21.9 хувиар буурч, Дундговь, Хөвсгөл, Нийслэл, Өвөрхангай, Баянхонгор, Сүхбаатар, Дорноговь, Төв, Өмнөговь, Орхон аймагт 0.9-44.6 хувиар нэмэгджээ.

Ял шийтгүүлэгчид Говьсүмбэр, Архангай, Баян-Өлгий, Дундговь, Завхан, Хэнтий, Говь-Алтай, Булган, Увс, Дархан-Уул аймагт 2.4-16.1 хувиар буурч, Хөвсгөл, Ховд,

Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, Баянхонгор, Дорноговь, Нийслэл, Төв, Өвөрхангай, Өмнөговь, Орхон аймагт 3.1-53.7 хувиар өссөн байна.

Анхаарал татаж байгаа эрүүгийн хэргийг авч үзвэл:

Д/д	Хэргийн төрөл	Хэргийн тоо				Ял шийтгүүлэгчид			
		Бүтэн жилд		Өсөлт, бууралт		Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2006 он	2007 он	тоо	хувь	2006 он	2007 он	тоо	хувь
1	Хүнийг санаатай алах	251	250	-1	-0.4	284	276	-8	-2.8
2	Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах	339	319	-20	-5.9	355	328	-27	-7.6
3	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	2276	2404	128	5.6	3518	3725	207	5.9
4	Танхайрах	518	552	34	6.6	753	823	70	9.3
5	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	85	129	44	51.8	174	289	115	66.1
6	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	481	517	36	7.5	505	550	45	8.9
7	Албан тушаалын гэмт хэрэг	15	16	1	6.7	23	34	11	44.8
8	Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх	53	44	-9	-17.0	85	63	-22	-25.9

байдалтай байна.

Эдгээр төрлийн гэмт хэрэг таслан шийдвэрлэсэн нийт хэргийн 72.6 хувь, ял шийтгүүлэгчдийн 71.9 хувийг эзэлж байгаа бол бусдын эд хөрөнгийг хулгайлах, танхайрах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн нийлбэр нь нийт хэргийн 60.0 хувийг эзэлж байна.

Өнгөрсөн оныхоос бусдыг санаатай алсан гэмт хэрэг 0.4, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэг 5.9 хувиар буурсан бол тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 7.5, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 5.6, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 51.8 хувиар тус тус өсчээ.

Ял шийтгүүлэгчдийн байдлыг авч үзвэл:

Д/д	Үзүүлэлт	Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2006 он	2007 он	тоо	хувиар
	Насанд хүрээгүй этгээд	727	963	236	32.5
	Эмэгтэйчүүд	660	710	50	7.6
	Гадаадын харьяат	54	52	-2	-3.7

	Урьд ял шийтгүүлсэн	1801	1904	103	5.7
	Гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн	1403	1496	93	6.6
	Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн	1726	1742	16	0.9
	Ажил, сургуульгүй хүмүүс	5240	4967	-273	-5.2

байдалтай байна.

Гэмт хэргийн улмаас нийтдээ 152 тэрбум 33 сая төгрөгийн хохирол учирч, 539 хүний амь хохирч, 2073 хүний биед хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл учирчээ.

Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн байдлыг авч үзвэл:

Д/д	Төрөл	Бүтэн жилд		Нийт ялын дотор эзлэх хувь	
		2006 он	2007 он	2006 он	2007 он
	<b>Нийт ял шийтгүүлэгчид</b>	<b>7792</b>	<b>8463</b>		
1	Хорих ялаар бүгд Үүнээс:	5454	5864	70.0	69.3
	а/ Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	2660	2859		
	б/ Тэнссэн	1930	2154		
	в/ Эрүүгийн хуулийн 62, 63-р зүйлээр шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан Үүнээс:	480	737		
	а/Насанд хүрээгүй этгээд	418	635		
	б/Жирэмсэн эмэгтэй 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг	62	102		
	г/ Өршөөл үзүүлсэн	384	114		
2	Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн Үүнээс:	2314	2573	29.7	30.4
	а/ Торгох ял	609	589		
	б/ Албадан ажил хийлгэх ял	538	671		
	в/ Баривчлах ял	1167	1313		
3	Бусад ял	24	26	0.3	0.3

байдалтай байна.

Ял шийтгүүлэгчдийн 69.3 хувьд хорих, 7.9 хувьд албадан ажил хийлгэх, 15.5 хувьд баривчлах, 0.3 хувьд онцгой ял тус тус оногдуулсны гадна, 6.9 хувь буюу 589 хүнийг 3 тэрбум 666 сая төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ. 2859 хүнд оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлсэн нь хорих ял шийтгүүлэгчдийн 48.7 хувь нь болж байна.

Шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ялыг 160 хүнд хэрэглэж 121.7 сая төгрөг гаргуулсны дээр, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 405 хүнд нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулжээ.

Нийт ял шийтгүүлэгчдийн 4172 буюу 49.2 хувьд хорих ялыг биечлэн эдлүүлсэн ба баривчлах ялаар шийтгэжээ. Хорих ялыг биечлэн эдлүүлсэн болон баривчлах ялын улсын дундаж хувь дээрмийн гэмт хэрэгт 99.0, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэгт 86.0 хувь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт 26.0 хувь, танхайрах гэмт хэрэгт 47.0 хувь, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт 18.0 хувь байна.

Шүүх хорих ял биечлэн эдлүүлсэн 2859 хүний 61.5 хувийг жирийн, 29.8 хувийг чанга, 8.4 хувийг онцгой, 0.3 хувийг гяндангийн дэглэмд ял эдлүүлэхээр тогтоожээ.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар эрүүгийн 1951 хэрэг хүлээн авснаас 1923 хэргийг хянан шийдвэрлэж, 1054 буюу 54.8 хувьд нь тогтоолыг хэвээр үлдээж, 407 буюу 21.2 хувьд нь тогтоолд өөрчлөлт оруулж, 462 буюу 24.0 хувьд нь тогтоолыг хүчингүй болгожээ. Оны эцэст 28 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2006 он	2007 он	2006 он	2007 он	зөрүү /+/, -/
Хянан шийдвэрлэсэн бүгд	1766	1923			
Хэвээр үлдээсэн	895	1054	50.7	54.8	4.1
Өөрчлөлт оруулсан	423	407	24.0	21.2	-2.8
Хүчингүй болгосон	448	462	25.3	24.0	-1.3
Үлдэгдэл	52	28			

Давж заалдах шатны шүүх 869 тогтоолыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 45.2 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар эрүүгийн 751 хэрэг хүлээн авснаас, 543 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 177 хэргийг хянаж, хариу өгсөн ба оны эцэст 31 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэн эрүүгийн хэргийн шийтгэх тогтоол, магадлалын 328 буюу 60.4 хувийг хэвээр үлдээж, 88 буюу 16.2 хувийг өөрчилж, 127 буюу 23.4 хувийг хүчингүй болгожээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь			
	2006 он	2007 он	2006 он	2007 он	зөрүү /+/, -/	
Хүлээн авсан хэрэг	759	751				
Хянан шийдвэрлэсэн бүгд	731	720				
Хянаад хүргүүлсэн	190	177				
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн	541	543				
Үүнээс:	Хэвээр үлдээсэн	321	328	59.3	60.4	1.1
	Өөрчлөлт оруулсан	69	88	12.8	16.2	3.4
	Хүчингүй болгосон	151	127	27.9	23.4	-4.5
Үлдэгдэл	28	31				

Хяналтын шатны шүүх 215 тогтоол, магадлалыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 39.6 хувийг эзэлж байна.

### Хоёр. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Анхан шатны шүүхүүд 41878 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авч, 8512 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, буцаах, харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж, бүгд 30699 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 3230 хэргээр буюу 11.8 хувиар өссөн байна. Оны эцэст 2667 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Хянан шийдвэрлэсэн нийт 30699 хэргийн 10141 буюу 33.0 хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 20558 буюу 67.0 хувийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцжээ.

Анхан шатны шүүхээр 2007 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг урьд онтой харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2006 он	2007 он	тоо	хувь
1	Архангай	672	550	-122	-18.2
2	Баян-Өлгий	617	775	158	25.6
3	Баянхонгор	691	819	128	18.5
4	Булган	853	599	-254	-29.8
5	Говь-Алтай	694	532	-162	-23.3
6	Говьсүмбэр	178	181	3	1.7
7	Дархан-Уул	1270	1297	27	2.1
8	Дорнод	1337	1286	-51	-3.8
9	Дорноговь	643	670	27	4.2
10	Дундговь	416	608	192	46.2
11	Завхан	908	1009	101	11.1
12	Орхон	1073	1238	165	15.4
13	Өвөрхангай	1438	1553	115	8.0
14	Өмнөговь	548	475	-73	-13.3
15	Сэлэнгэ	2475	2096	-379	-15.3
16	Сүхбаатар	536	442	-94	-17.5
17	Төв	679	1086	407	59.9
18	Увс	650	737	87	13.4
19	Ховд	811	962	151	18.6
20	Хөвсгөл	1090	1367	277	25.4
21	Хэнтий	893	674	-219	-24.5
22	Нийслэл	8997	11743	2746	30.5
	Дүн	27469	30699	3230	11.8

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг Дорнод, Өмнөговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Архангай, Говь-Алтай, Хэнтий, Булган аймагт 3.8-29.8 хувиар буурч, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Өвөрхангай, Завхан, Увс, Орхон, Баянхонгор, Ховд, Хөвсгөл, Баян-Өлгий, Нийслэл, Дундговь, Төв аймагт 1.7-59.9 хувиар өсчээ.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

төрөл	Бүтэн жилд	Нийт хэрэгт эзлэх хувь	Зөрүү /+/, -/
-------	------------	------------------------	---------------

	2006 он	2007 он	2006 он	2007 он	
<b>Нийт иргэний хэрэг</b>	<b>27469</b>	<b>30699</b>			
Иргэний эрх зүйн маргаан	11715	11792	42.6	38.4	-4.2
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар	9090	9316	33.1	30.3	-2.8
Гэр бүлийн эрх зүйн маргаан	2989	3544	10.9	11.5	0.6
Хөдөлмөрийн эрх зүйн	711	657	2.6	2.1	-0.5
Бусад эрх зүйн маргаан	2964	5390	10.8	17.7	6.9
Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар	129	48			
Дампуурлын хуулиар	52	6			
Компаний тухай хуулиар	59	6			
Нийгмийн даатгалын багц хуулиар	239	1057			
Патентийн хуулиар	2	2			
Зохиогчийн эрхийн тухай хуулиар	3	2			
Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	27	7			
Төрийн албаны тухай хуулиар	3	5			
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар	3	0			
Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулиар	247	189			
Бусад хуулиар	2200	4068			

Нийт хэрэгт иргэний эрх зүйн маргаан 38.4, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн маргаан 30.3, гэр бүлийн эрх зүйн маргаан 11.5, хөдөлмөрийн эрх зүйн маргаан 2.1 хувийг тус тус эзэлж байна.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар 1419 хэрэг хүлээн авснаас 1350 хэргийг хянан шийдвэрлэж, үүнээс 446 буюу 33.0 хувьд нь шийдвэрийг хэвээр үлдээж 406 буюу 30.1 хувьд нь шийдвэрт өөрчлөлт оруулж, 498 буюу 36.9 хувьд нь шийдвэрийг хүчингүй болгож, оны эцэст 69 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2006 он	2007 он	2006 он	2007 он	зөрүү /+/, -/
Хянан шийдвэрлэсэн бүгд	1364	1350			
Хэвээр үлдээсэн	573	446	42	33	-9
Өөрчлөлт оруулсан	368	406	27	30.1	3.1
Хүчингүй болгосон	423	498	31	36.9	5.9
Үлдэгдэл	53	69			

Давж заалдах шатны шүүх 904 шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 67.0 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар иргэний 931 хэрэг хүлээн авч, 195-г хянан хариу өгч, 708 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, шийдвэр, магадлалын 285 буюу 42.2

хувийг хэвээр үлдээж, 244 буюу 36.1 хувийг өөрчилж, 146 буюу 21.7 хувийг нь хүчингүй болгож, 28 хэргийн үлдэгдэлтэй байв.

	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь			
	2006 он	2007 он	2006 он	2007 он	зөрүү /+/, -/	
Хүлээн авсан хэрэг	1079	931				
Хянан шийдвэрлэсэн бүгд	1032	903				
Хянаад хүргүүлсэн	251	228				
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн	781	675				
Үүнээс:	Хэвээр үлдээсэн	326	285	41.8	42.2	0.4
	Өөрчлөлт оруулсан	183	244	23.4	36.1	12.7
	Хүчингүй болгосон	272	146	34.8	21.7	-13.1
Үлдэгдэл	47	28				

Хяналтын шатны шүүх 390 шийдвэр, магадлалыг өөрчилж хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 57.8 хувийг эзэлж байна.

#### **Гурав. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар**

Захиргааны хэргийн шүүхүүд 2007 онд 998 нэхэмжлэл, гомдол хүлээн авч, 287 нэхэмжлэлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх буюу захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангуулахаар нэхэмжлэгчид нь буцааж, 591 хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 160 хэргээр буюу 37.1 хувиар өсчээ.

Оны эцэст 120 хэргийн үлдэгдэлтэй гарсны дотор хуульд заасан үндэслэлээр 14 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, 42 хэргийн шүүх хуралдааныг хойшлуулж, 64 хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

2007 онд хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг шүүх тус бүрээр үзүүлбэл:

Д/д	Шүүх	Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2006 он	2007 он	Тоо	Хувь
1	Архангай	7	7	0	0.0
2	Баян-Өлгий	25	27	2	8.0
3	Баянхонгор	10	15	5	50.0
4	Булган	5	8	3	60.0
5	Говь-Алтай	3	2	-1	-33.3
6	Говьсүмбэр	6	6	0	0.0
7	Дархан-Уул	6	11	5	83.3
8	Дорнод	31	13	-18	-58.1
9	Дорноговь	4	16	12	3 дахин
10	Дундговь	3	3	0	0.0
11	Завхан	9	5	-4	-44.4
12	Орхон	13	32	19	1.4 дахин
13	Өвөрхангай	6	21	15	2.5 дахин
14	Өмнөговь	9	5	-4	-44.4
15	Сүхбаатар	13	22	9	69.2
16	Сэлэнгэ	13	10	-3	-23.1

17	Төв	14	15	1	7.1
18	Увс	8	11	3	37.5
19	Ховд	6	9	3	50.0
20	Хөвсгөл	19	17	-2	-10.5
21	Хэнтий	10	11	1	10.0
22	Нийслэл	211	325	114	54.0
	Дүн	431	591	160	37.1

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл,

Хэргийн төрөл	Бүтэн жилд		Нийт хэрэгт эзлэх хувь	
	2006 он	2007 он	2006 он	2007 он
Нийт захиргааны хэрэг	431	591		
Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хуулиар	15	11	3.5	1.9
Төрийн албаны тухай хуулиар	74	68	17.2	11.5
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар	14	14	3.2	2.4
Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар	18	39	4.2	6.6
Газрын тухай хуулиар	89	129	20.6	21.7
Ашигт малтмалын тухай хуулиар	28	50	6.5	8.5
Татварын ерөнхий хуулиар	31	38	7.2	6.4
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулиар	10	14	2.3	2.4
Бусад хуулиар	152	228	35.3	38.6

байдалтай байна.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах журмаар 290 хэрэг хүлээн авснаас, 8 хэргийг хуралдаанд оруулахгүйгээр шийдвэрлэн, 262 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, үүнээс 55.7 хувь буюу 146 шийдвэр, захирамжийг хэвээр үлдээж, 15.3 хувь буюу 40 шийдвэрт өөрчлөлт оруулж, 29.0 хувь буюу 76 шийдвэр, захирамжийг хүчингүй болгож, оны эцэст 20 хэргийн үлдэгдэлтэй гарчээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
	2006 он	2007 он	Тоо	Хувь
Хүлээн авсан хэрэг	180	290	110	61.1
Хуралдаанд оруулахгүйгээр шийдвэрлэсэн	12	8	-4	-33.3
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн	159	262	103	64.8



Үүнээс	Хэвээр үлдээсэн	81	146	65	55.7
	Өөрчлөлт оруулсан	22	40	18	15.3
	Хүчингүй болгосон	56	76	20	29.0
Үлдэгдэл		9	20	11	1.2 дахин

Хяналтын журмаар ирүүлсэн 201 захиргааны хэргээс Ерөнхий шүүгчид 42 гомдол гаргаснаас 40, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулахаар ирүүлсэн 6, 136 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, 4 хэргийг хуралдаанд оруулахгүйгээр шийдвэрлэж, оны эцэст 15 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэн 136 хэргийн 57.3 хувь буюу 78 шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, 26.5 хувь буюу 36 шийдвэр, магадлалыг өөрчилж, 16.2 хувь буюу 22 шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Өсөлт, бууралт		
	2006 он	2007 он	Тоо	Хувь	
Хүлээн авсан хэрэг	107	201	94	87.9	
Ерөнхий шүүгчид гомдол гаргасан		40			
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулсан		6			
Хуралдаанд оруулахгүйгээр шийдвэрлэсэн	2	4	2	1 дахин	
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн	102	136	34	33.3	
Үүнээс:	Хэвээр үлдээсэн	55	78	23	57.3
	Өөрчлөлт оруулсан	17	36	19	26.5
	Хүчингүй болгосон	30	22	-8	16.2
Үлдэгдэл	3	15	12	4 дахин	

### **Дөрөв. Бусад асуудлаар**

Анхан шатны шүүхүүд захиргааны зөрчлийн 15546 (+332) материалыг хянан хэлэлцэж, 949 (-118) хүнийг 12.9 (+1.5) сая төгрөгөөр торгож, 14490 (+403) хүнд баривчлах, 25 (+23) хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах шийтгэл тус тус ногдуулж, 82 (+24) хүнд захиргааны шийтгэл ногдуулахаас татгалзсан байна.

Тайлангийн хугацаанд шүүхүүд хоригдлыг хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих болон ял эдлэх дэглэмийг өөрчлүүлэх тухай 1469 (-224) материалыг хянан хэлэлцэж, 59 (+32) санал дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож, 985 (-109) хоригдлыг эдлээгүй үлдсэн хорих ялаас нь тэнсэн суллаж, 26 (+5) хоригдлын хорих ялыг хорихоос өөр төрлийн хөнгөн ялаар сольж, 399 (-132) хоригдлын ял эдлэх дэглэмийг өөрчилжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 2024 (+175) сэжигтнийг баривчлах тухай материалыг хүлээн авч, 1946 (+265) сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 78 (-90) сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд зааснаар 2824 (+441) хүнийг сэжигтнээр, 3645 (+818) хүнийг яллагдагчаар цагдан хорьж, 183 (-20) хүнд цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

Иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад улсын тэмдэгтийн хураамжид 1 тэрбум 231.8 сая (-70.6) төгрөг, үүнээс анхан шатны шүүх 1 тэрбум 115.2 сая төгрөг (-68.2), давж заалдах шатны шүүх 76.0 сая (+2.8) төгрөг, хяналтын шатны шүүх 40.5 сая (-5.3) төгрөгийг улс, орон нутгийн орлогод оруулахаар шийдвэрлэв. Хяналтын шатны шүүхээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 13.4 сая (-93.7) төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг зохигчдод буцаан олгохоор шийдвэрлэсэн байна.

Анхан шатны шүүхүүд нийт 72287 хэрэг, маргааныг шийдвэрлэсний дотор эрүүгийн 6507, иргэний 39211, захиргааны 878 хэрэг, захиргааны зөрчил 15546, хоригдлыг ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих болон ял эдлэх дэглэмийг өөрчлүүлэх тухай 1469 хүсэлт, 2024 сэжигтнийг баривчлах, 6652 хүнд цагдан хорих зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хэлэлцсэн байна.

Аймаг, нийслэлийн захиргааны хэргийн нэг шүүгч дунджаар захиргааны 15, сум, сум дунд, дүүргийн шүүхийн нэг шүүгч дунджаар 286 хэрэг, маргаан тус тус хянан шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхүүд эрүүгийн 1923, иргэний 1350 бүгд 3273 хэрэг хянан шийдвэрлэжээ. Үүнээс нийслэлийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч дунджаар 77, аймгуудын давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч дунджаар 24 хэрэг, маргаан тус тус хянан шийдвэрлэсэн байна.

2007 онд Хяналтын шатны шүүх буюу Улсын Дээд шүүх эрүүгийн 720, иргэний 903, захиргааны 456, нийтдээ 2079 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Дээд шүүхийн нэг шүүгчид дунджаар эрүүгийн хэрэг 144, иргэний хэрэг 181, захиргааны 76 хэрэг тус тус ногдож байна.

Монгол улсын шүүхүүд 2511 өргөдөл, гомдол хүлээн авснаас 2393 буюу 95.3 хувийг шийдвэрлэн, зохих хариуг иргэн, хуулийн этгээдэд өгсөн ба одоо 118 өргөдөл, гомдлыг хянаж байна.

## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ